

## ТАНИЛЦУУЛГА

2014.07.07

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 274.8-д “Төрийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хяналт-шинжилгээ үнэлгээний чадавхийг сайжруулна.” гэж төлөвлөсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-т “цагдаагийн байгууллагад үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх” зорилт тусгагдсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний үзүүлэлтийг Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээний аргачлал”-ын хоёрдугаар хавсралтаар тогтоосон.

Энэ үзүүлэлтийг практикт хэрэглэх явцад үйл ажиллагааны үр дүнг оноо, хувиар бодитой тооцон үнэлэх бус зөвхөн үйл ажиллагааны үр дүнгийн статистик мэдээлэл, түүний өмнөх онтой харьцуулсан өсөлт, бууралтыг л харуулж байгаа юм.

Иймд үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний үзүүлэлтүүдийг шинэчлэн тогтоож, тэдгээрийн чанарыг нь хэмжих, үйл ажиллагааны үр дүн зорилтот түвшний хаана байгааг шууд харах зорилгоор үзүүлэлт тус бүрт шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг шинээр тодорхойлж боловсрууллаа.

Журам, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийн төсөл, тэдгээрийг тооцох заавар боловсруулах ажлын хүрээнд ажлын хэсэг байгуулсан, төв орон нутгийн байгууллагуудад хүргүүлж эхний улирлын байдлаар туршуулан саналыг нь авч нэгтгэсэн, саналыг судлан үзээд хэлэлцсэн.

Үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтэд шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тогтоон ашиглах нь дараах ач холбогдолтой.

1. Үйл ажиллагааны үр дүнг бодитой үнэлж, дүгнэнэ.
2. Иргэний зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
3. Хөндлөнгийн байгууллагаас хэрэглэгчийн үнэлгээ болон бүх төрлийн судалгаа хийх мэдээллийн бааз бэлтгэгдэнэ. .
4. Хүнийг эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх бололцоо бүрдэнэ.

Цаашид журам хэрэгжих, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг хэрэглэх боломжтой түвшинд хүртэл сайтар нягтлан үзэж дахин боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС